



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

Баянзүрх дүүргийн төр захиргааны II байр,
Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13320
Утас: (976) 7015 4446

Цахим шуудан: Bzd.khaaa@gmail.com

2024.11.22 № 612

танай _____-ны № _____-г

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлт захиалагчид ирүүлсний дагуу хариуг хүргүүлж байна. Үүнд:

1.Тус албанаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зарласан “Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 34 дүгээр хороо)”, БШУЯ/20240101060 дугаартай тендер шалгаруулалт нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас эрх шилжиж ирсэн бөгөөд ажлын зураг, төсөв боловсруулах даалгаврыг холбогдох байгууллагаас боловсруулж, баталж ирүүлсэн болно. Үүнтэй холбоотойгоор газрын гэрчилгээ, кадастрын зургийг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэл удирдлагын хэлтсийн мэргэжилтэн М.Билэгжаргал (утас:88046040)-аас тодруулж, дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 50 дугаар зүйлд заасны дагуу худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтны бүрэлдэхүүнтэйгээр Үнэлгээний хороо байгуулагдаж, хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дах хэсэгт тус тус зааснаар Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын тендерийн жишиг баримт бичиг”-ийн дагуу шалгуур үзүүлэлтийн бичиг баримт боловсруулалтыг тендер шалгаруулалтын нарийн бичиг хурлыг товыг гишүүдэд мэдэгдэж, хэлэлцэж, сонсож, шийдвэрлэж, захиалагчаар батлуулан хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангаж зарласан байна.

Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1.ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт; гэж заасан байдаг. Иймд дээрх тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийн II бүлгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-ийн “3.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана” Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын нийлбэрээр жилд доод тал нь нэг удаа тусгай зөвшөөрлийн хүрээнд үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.” Гэж боловсруулж тусгасан нь уг хуулийн заалтыг зөрчөөгүй буюу сүүлийн гурав хүртэлх жилийн хугацааны дотор байсан тул тендерийн баримт бичгийг баталж, тендер шалгаруулалтыг зарласан болно.

Мөн Сонирхогч этгээд болон оролцогч нь Захиалагч тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг өрсөлдөөнийг хязгаарласан тендер зарласан гэж үзэж байвал хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу Өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (Монополын эсрэг газарт)-д гомдол гаргах эрхтэй болохыг зөвлөө.